

Монголын гадаад харилцааны түүхэн уламжлал бол Хүннү гүрэн, Орхоны Түрэг, Их Монгол улсын зэрэг Хятадын Цагаан хэрмээс Байгал Нуур, Хянганы нурууны зүүн талын уудам хээрээс Алтан, Тарвагатайн баруун бэл хүртлэх дэвсгэр нутаг дээр үеийн үед үүрд оршин тогтож байсан монгол, түрэг угсааны олон янзын улс аймгийн гадаад харилцааны холбогдолтой маш том, нарийн асуудал юм.

Он цагийн хувьд Монголын гадаад харилцааны түүх Монгол нутагт анхны төр улс үүссэн 2201 жилийн тэртээх эрт дээр үеэс ч хамаагүй урагш халин гарч байна. Монгол, Зөвлөлтийн эрдэмтэд манай улсын нутаг дэвсгэр дээр одоогоос хагас сая гаруй жилийн өмнө хүний өвөг дээдэс оршин амьдарч байсны ул мөрийг нээж олсон. Энэ 1993 оны 4-р сард Хятадын эрдэмтэд Өвөр Монголоос, тухайлбал Хөх хотын дэргэдээс 700 мянган жилийн өмнөх хүний өвөг дээдсийн эдэлж хэрэглэж байсан хуучин чулуун зэвсгийн доорд шатны багаж зэвсэг, эд хэрэглэл олж, шинэ нээлт хийлээ.

Тийм эрт дээр үед Монгол, Хятад, Орос гэх зэрэг угсаатан байтугай шар, хар, цагаан арьстны ялгаа зааг гараагүй байсан ч гэсэн дараа дараачийн үеэс нь монголчуудын өвөг дээдэс Төв Азийн өргөн уудам уул талын бүсэд ялгаран гарч түрэг, манж, хятад, иран, урал, алтайн язгуур хэлтний өвөг дээдэстэй удам угсаа, хэл соёл, зан заншил, эдийн засаг, ахуй амьдралын янз бүрийн харилцаа холбоотой болоод байжээ. Гэсэн ч бид гадаад харилцааны түүхэн уламжлалыг Монгол нутаг дээр анхны төр улс бий болсон Хүннү гүрэн, Сяньби улс, ялангуяа Чингис хааны үед үүсэн бүрэлдсэн Монголын үндэсний нэгдсэн улсын үеэс эхэлж ярих нь зүйтэй болов уу.

Хүннү гүрэн, Сяньби улсын үед Монголын төр улс, гадаад харилцааны түүхэн уламжлалын үндэс суурь нэгэнт тавигдсан байна. М.Э.Ө. 198 онд Хүннү гүрэн эртний Хятадын Хан улстай эрх тэгш гэрээ байгуулж, Цагаан хэрмээр улсын хилийг анх удаа албан ёсны гэрээ хэлэлцээрийн баталгаатай тогтоож байжээ.

Монгол нутагт төвлөрч байсан Түрэгийн хаант улс ч гэсэн Хятадын хүчирхэг их Тан улстай эн сацуу харилцаж, зарим үед түүнд санаа зоригоо тулган хвлээлгэж чаддаг байжээ.

Чингис хаан, Их Монгол улс болон Монголын эзэнт гүрний төр, засаг нь Умард Хятадад ноёлж байсан манж-түнгүс угсааны Зүрчидийн Алтан улс, Дундад Ази, нийт лалын ертөнцийн дийлэнх ихэнхийг эзэгнэн захирч байсан Хорезм гүрний эрх баригчидтай эн сацуу харилцааар үл барам, цэрэг-улс төрийн болон дипломат харилцааны янз бүрийн арга хэрэгслийг чадамгай хэрэглэж байгаад эрхшээл нөлөөндөө оруулж авсан байдаг. Их Монгол улсын гадаад харилцаа нь Японоос Англи, Шри Ланка, Египтээс Якут хүртлэх Ази, Европ, Африкийн олон улс орныг хамарч байв.

Хүннү гүрэн, Түрэгийн хаант улс, Их Монгол улс гурвын гадаад харилцааны байдал төрхийг ажиглахад магадтай их гүрний гадаад харилцааны шинжтэйгээр барахгүй одоогийн нэр томъёо хэрэглэж яривал олон талаар хэт их гүрнүүдийн гадаад харилцааны шинж төрхийг биедээ агуулж байсан сэтгэгдэл төрүүлдэг.

* Академич, доктор, профессор

Эзэнт гүрэн мөхсөний дараа Монголын төр ёс, гадаад харилцааны уламжлал тасарсангүй, цаашид тасралтгүй үргэлжлэн хөгжсөөр байсан юм. Монгол улс феодалын дотоодын зөрчил тэмцлээс болж, эхлээд хоёр, дараа нь гурван улс болж хуваагдан байсан ч гэсэн нэгдмэл байдлаа сэргээн бэхжүүлэх талаар дотоод, гадаад бодлогын янз бүрийн арга сэдэж хэрэгжүүлэн зарим үр дүнд хүрч байв. XVI зууны үед Түмэн Засагт хааны санаачилга, чиглүүлгээр Өвөр Монголын Алтан хан, Халхын Абтай хан, Ойрадын Мэргэн тэвнэ нар Төвдөөс буддийн шашин авч хэрэглэсэн нь зөвхөн сүсэг бишрэлийн асуудал биш байв. Хятадын Мин улсын эрх баригчид Монголд буддын шашныг өөрийн орны хүрээ хийдээс нэвтрүүлж дэлгэрүүлэхийг хүчлэн оролдож байсан боловч монголчууд тэрхүү шашныг чухамхүү Түвдээс авсан нь гадаад бодлогын ихээхэн нарийн, холбогдол учир бүхий зүйл байв. Монгол улсын төр, засаг нь буддын шашныг үзэл суртлын ихээхэн хүчирхэг арга хэрэгслийнх нь хувьд Мин улсаас оруулж дэлгэрүүлбэл Хятадын эрхшээл нөлөөнд эргэлт буцалтгүй татагдан орохоос ихэд болгоомжилж байжээ. Монгол хаад, ноёд харин, буддын шашныг өөрийнхтэйгээ адил төсөөтэй нүүдлийн соёл иргэншилт Түвдээс шууд оруулан ирж, Түвд улстай улс төр, үзэл суртлын эвсэл холбоо байгуулж, хөрш зэргэлдээх хүчирхэг их гүрнүүдийн түрэмгийллээс өөрийн тусгаар тогтнол, биеэ даасан байдлыг сэргийлэн хамгаалах шинэ арга сэдэж байжээ. Хамгийн гол нь Монгол улсын төрийн эрх баригчид улс орныхоо дотоод нэгдэл нягтралыг сэргээн бэхжүүлэхэд гүн, нарийн, нууцын увьдастай шарын шашныг өөрийн үзэл суртлын тулгуур хүчин болгож ашиглан, үндэстний соёлыг шинэ үндсэн дээр сэргээн мандуулж, улс орноо энх тайван нөхцөлд өв тэгш хөгжүүлэх зам шилсэн байна. Мөн тэр зорилгоор 1586 онд Халхын буддын шашны төв Эрдэнэзуу хийдийг байгуулж, 1639 онд Монголын шарын шашны тэргүүн Өндөр гэгээн Занабазарыг тодруулан гаргаж ирсэн юм. Өндөр гэгээн бол Халхын хаант улс буюу нийт Ар Монголын төрийн тэргүүн, Чингисийн шууд угсааны сурвалжит язгууртан ноён, Түшээт ханы хүвгүүн байсан учир түүнийг шарын шашны тэргүүн болгож албан ёсоор тунхаглан өргөмжилсөн нь Монголын төрийн дотоод, гадаад бодлогын нарийн асуудал байсан юм. Дорнодахин, Олон улс судлалын хүрээлэн, Зүүн хойт Азийн судалгааны төвийн шинжилгээний ажлын үр дүн, зарим эрдэмтэн, мэргэжилтний ажиглалт ёсоор Халхын хан, ноёд төрийн ёс, номын ёс хоёрыг нэгэн зэрэг хавсарган хэрэглэж улс нийгмийг цогцолбор жолоодлогоор хангах тухай Энэтхэг, Түвдийн буддын сургаалын хоёр ёсны онолыг баримталж, Монголд шашин, төрийг хослон барьсан төрийн тэргүүнтэй болж, дотоод, гадаад бодлогыг төвлөрүүлэн нэгтгэж цэгцлэх шинэ үйл ажиллагаа эхэлсэн байдал илт харагдаж байна.

Гэтэл өндөр гэгээний үед Халхын гадаад, дотоод байдал Монголд хамгийн ашиггүй, туйлын хөнөөлттэйгээр эргэж, Манж, Орос хоёрын аль нэгний эрхшээлд орохоос өөр замгүй болсон юм. Тийм нөхцөлд Өндөр гэгээн Манж, Оросын аль нь ч Хятад биш, хоёулаа шинэ араатан, Гэхдээ Орос нь илүү хүчирхэг, их ирээдүйтэй, түүний мэдэлд нэг орвол эргээд мултарч чадахгүй, Манжийн сүр хүчин хэдий бадралч уг нь жижигхэн улс түмний хэврэгхэн төр, хэзээ нэгэн цагт эзлэгдэн ноёрхогдож байгаа. Хятад, Монголын эсэргүүцэл тэмцэлд автаж, зайлшгүй мөхнө, тэгэх цагт Монгол магадтай чөлөөлөгдөн төрийн тусгаар тогтнолоо сэргээн мандуулж чадна гэсэн улс төрийн гадаад бодлогын нарийн тооцон дээр тулгуурлаж, Манжид түр дагаар орохыг зөвшөөр-

сөн болохоос өөр аргагүй байдалд тулгагдан орсон бололтой байдаг. Тухайн үеийн түвд хэл дээрхи түүхэн сурвалж бичгийг судалж байгаа манай зарим мэргэжилтэн Өндөр гэгээн бол анх Манжид дагаар орно гээгүй, зөвхөн түр түшиглэнэ гэсэн байна, түшиглэнэ гэсэн үг дагаар орно гэсэн зүйл огтхон ч биш юм гэж байгаа нь нарийн учиртай болов уу, үнэхээр Өндөр гэгээн Долоон нуурын чуулган дээр Монголыг Манжид дагаар оруулах ёслол хийхэд эхэр татан енгинэтэл үйлж байсан нь Манж, Хятад, Монгол түүхийн албан сурвалжид ч тодорхой тэмдэглэгдэж үлдсэн байдаг.

Манжид эзлэгдсэн явдал Монголын төрийг мөхөөж ихээхэн хор хохирол учруулсан боловч Монголын төр ёс, гадаад харилцааны түүхэн уламжлалыг бүр мөсөн тас цохин устгаж хараахан чадаагүй юм. Манжийн төрийн ёсонд Хятадын төр, күнзийн сургаалын олон зүйл нэвтэрсэн боловч манжийн хаад төр улсаа байгуулсан анхны үеэс эхлэн Монгол бичгийг төрийн бичиг болгож, Монголын Юан улсын төрийн ёс, гадаад харилцааны уламжлалыг голчлон авч хэрэглэсэн юм. Монгол оронд, монгол хүмүүсийн үзэл бодол, санаа сэтгэл, цааз хууль, засаг захиргаа, цэрэг иргэн, ахуй амьдралын бүх салбарт Монголын төр ёс, гадаад бодлогын түүхэн уламжлал амь бөхтэй хадгалагдан үлдэж, аажмаар нарийсан боловсорч байсан талтай. Учир нь Манжийн ноёрхлын үед Чингисийн угсааны алтан ургийн төрийн бодлоготонгууд бараг хуучин хэвээр хадгалагдан үлдсэнээр барахгүй шинэ бий болсон шашны номын ёсны төрийн дотоод, гадаад бодлоготны эгнээ эрс өргөжиж, Монголд төр, шашны нэгдмэл гадаад бодлогын бүхэл бүтэн хүчирхэг цогцолбор зангидагдан гарч иржээ.

Энэ бүхэн нь 1911 онд Монголд үндэсний эрх чөлөөний хувьсгал ялж, тусгаар тогтнолоо тунхаглан, гадаад харилцааны нарийн бодлого, дипломатын чадамгай үйл ажиллагаа бэлэн зэлэн явуулсанд тусгалаа олсон байдаг.

1921 оны ардын хувьсгал мандах үеэр Монгол улс нь иргэний ба шашны чиглэлийн төрийн бодлоготнуудтай, шашин, төр хосолсон гадаад харилцааны бат уламжлалтай байсны дээр Орос, Европын орчин цагийн гадаад харилцааны ёс, дэглэмээс нэгэнт суралцаж эхлээд байв. 1920-30-аад оны үеэст орчин цагийн дипломат ёсны мэдлэг, чадвартай болсон хөдөлмөрчин ард, жирийн сэхээтний гаралтай төрийн бодлоготон, гадаад харилцааны мэргэжлийн хүмүүс гарч ирсэн байна. Гэтэл харамсалтай нь 1922, ялангуяа 30-аад оны үеэс Чингисийн угсааны ууган төрийн бодлоготон, шашны төрийн бодлоготон, ард сэхээтэн гаралт төрийн бодлоготонгууд цөм бараг толгой дараалж хядагдаж, хэлмэгдэх болсон нь Монголын гадаад харилцааны уламжлалд урьд огт үзэгдээгүй ноцтой хохирол учруулсан юм. Манайд одоо цөөн тооны төрийн бодлоготон, нэлээд тооны гадаад харилцааны мэргэжилтэй боловсон хүчин шинээр бий болоод байгаа ч гэсэн хэдэн арван жилийн хэлмэгдүүлэг, завхруулгын хор уршиг нь ардчилал, шинэчлэл, зах зээлд шилжиж, төрийн тусгаар тогтнол, эдийн засаг, соёлын биеэ даасан байдал, улс үндэстний нийтлэг бүрэн эрхт байдлыг зохих ёсоор тавьж, шинэ үндсэн дээр сэргэн мандахад ноцтой мэдрэгдэж байх шиг байна.

Ардчилал, шинэчлэл, зах зээлийн шилжилтийн үед манай улсад нэн чадвартай төрийн бодлоготон олноор төрж, гадаад харилцааны үндэсний шив шинэ уламжлал удаж төдөхгүй бүрэлдэн тогтоно гэдэгт итгэн найдахыг хүснэм.

1993.06.28.